



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 2/118

Улаанбаатар хот

Б.Ариунжаргалыг албан тушаал бууруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.3 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5, 17.1.7 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.6, 13.8, 13.8.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.10 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/17852 дугаар албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Базаррагчаагийн Ариунжаргал нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан “Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй” гэснийг зөрчсөн нь Авлигатай тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/17852 дугаар албан бичиг, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнийг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөр дуусгавар болгон албан тушаал бууруулж, тус өдрөөс Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчээр томилсугай.

2.Б.Ариунжаргалд 11/81 дугаартай улсын ахлах бүртгэгчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

3.Б.Ариунжаргалын иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцалж, шинээр эрх нээхийг Иргэний улсын бүртгэлийн газар /Г.Нармандах/, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар /Т.Төгөлдөр/-т даалгасугай.

4.Албаны нууцтай танилцах эрх олгон, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулахыг нэгжийн нууц хамгаалах ажилтан /Г.Анхныбаяр/-д үүрэг болгосугай.

5.Б.Ариунжаргалын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг ТЗ-6-д хамааруулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 26 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, хоол унааны нөхөх төлбөрийг холбогдох журмын дагуу тооцон олгохыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/-т зөвшөөрсүгэй.

6.Тушаалын биелэлтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН